



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/50

Модот

Г Хязгаарлалтын дэглэм тогтоох Г
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22, 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.3, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Тус сумын Баянмод багийн ("Бургаст") N47,811175, E109.095044, нэртэй газарт малын гоц халдварт боом өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн тул 2026 оны 04 дүгээр сарын 02-оос тодорхойгүй хугацаагаар хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2.Малын боом өвчний сэжигтэй тохиолдлоор үхсэн малыг устгал хийх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай

3.Малын гоц халдварт боом өвчний сэжигтэй бүсэд хяналтын пост, хөдөлгөөнт эргүүл гаргаж холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Ганзоригт)-т, боом өвчнөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээг малчдад хүргэж ажиллахыг Баянмод багийн Засаг дарга (С.Энхнар)-д үүрэг болгосугай

4.Малын гоц халдварт боом өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн бүсийн малд болон үзлэг тандалт халдваргүйтгэл хийх ажлыг "Үржих баян мандал" МЭҮН-ийн малын эмч (Э.Баасансүрэн)-д, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч (П.Ганчимэг)-т хариуцуулсугай

5.Хязгаарлалтын дэглэм тогтоосонтой холбогдуулан шаардагдах шатах, тослох материал, халдваргүйжүүлэлтийн хувцас, хэрэгсэл, ариутгалын бодисоор хангах зардлыг Эрсдлийн сангаас 2,000,000 (Хоёр сая төгрөг)-ийг санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Б.Буяндэлгэр) -т зөвшөөрсүгэй.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахын Засаг даргын Тамгын газрын дарга (Ү.Ичинхорлоо)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



А.МӨНХ-ОРГИЛ

Сумын Засаг даргын 20²⁶
...04 дүгээр сарын 03-ны
өдрийн... А/50... дугаар
захирамжийн хавсралт

Малын боом өвчний сэжигтэй тохиолдлоор үхсэн малыг устгал хийх
ажлын хэсэг

Ахлагч	П.Ганчимэг	- Мал эмнэлгийн Улсын бацаагч
Гишүүд	Э.Баасансүрэн	- Малын эмч
	С.Энхнар	- Багийн Засаг дарга
	Э.Энхтүвшин	- ТҮК дарга
	С.Ганпүрэв	- Туслах ажилтан
	Ш.Бямбадорж	- Туслах ажилтан
	Э.Жаргал	- Туслах ажилтан
	Н.Мөнхбат	- Туслах ажилтан
	М.Мөнхтулга	- Жолооч

_____000_____